

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын
даргын 2025 оны 08 дугаар сарын 25-ны
өдрийн 4/105 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

“ДААТГУУЛАГЧДАД ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ” БАЙГУУЛАХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХЭД БҮРДҮҮЛЭХ
МАТЕРИАЛ, ТАВИГДАХ ШАЛГУУР

№	БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ	ШАЛГУУР
1.	Албан хүсэлт	<ul style="list-style-type: none"> Албан хүсэлтэд “Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах” гэрээ байгуулах тухай хүсэлтээ тусгасан байх. Эргэх холбоо тогтоох хаяг, байршил, цахим хаяг, утасны дугаар тодорхой бичиж ирүүлсэн байх.
2.	Эмийн сангийн мэдээллийн маягт	<ul style="list-style-type: none"> Эмийн сангийн мэдээллийн маягыг бүрэн хөтөлж, эрх бүхий албан тушаалтан баталгаажуулсан байна.
3.	Улсын бүртгэлийн гэрчилгээ; /хуулбар хувь байж болно/	<ul style="list-style-type: none"> Улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх үйл ажиллагаа нь эм барих, эмийн худалдааны чиглэлтэй байх.
4.	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ; /хуулбар хувь байж болно/	<ul style="list-style-type: none"> Тусгай зөвшөөрөлд түүний дугаар, код, эмийн сангийн эрхлэгч, эмийн сангийн хаяг, байршил тэмдэглэгдсэн байх. Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын өөрчлөлт орсон тохиолдолд эрх бүхий байгууллагаар хаягийн өөрчлөлтийг хийлгэсэн байх. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа хүчинтэй байх.
5.	Хүний нөөцтэй холбоотой мэдээлэл	<ul style="list-style-type: none"> Эм зүйч, эм найруулагч нарын Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар; Эрүүл мэндийн ажилтны мэдээллийг Хүснэгт-1 дагуу ирүүлэх; Эмийн сангийн бүтэц орон тооны тушаал;/ тухайн компани 2 ба
		<ul style="list-style-type: none"> Эм зүйч, эм найруулагч нарын эм барих лицензийн хугацаа хүчинтэй байх Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартын А хавсралтад заагдсан шаардлагыг хангасан байх. Тухайн компани нь 2 ба түүнээс дээш эмийн сантай бол бүтэц орон тооны тушаалд хүний нөөцийн

	түүнээс дээш эмийн сантай бол/	мэдээллийг тодорхой тусгасан байх.
6.	Эмийн сангийн нийт ажилтныг ажилд томилсон тушаал, хөдөлмөрийн гэрээний хуулбар;	<ul style="list-style-type: none"> • Тухайн ажлын байранд тушаалаар томилсон байх. • Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болоогүй байх.
7.	Нийгмийн даатгалын шимтгэлийн НД-7, 8 тайлан;	<ul style="list-style-type: none"> • Эмийн сангийн ажилтнууд нь сүүлийн 3 сар НДШ-ийн НД 8 тайланд 01 кодоор (22 код байж болно) тасралтгүй төлсөн байх. (Хэрэв 6, 17 кодоор төлсөн бол орлон ажиллах хүн нь заавал 01, 22 кодоор төлсөн байх) • Нийтийн үйлчилгээтэй, эмнэлгийн эмийн сангаас шалтгаалж, MNS 5260:2015 стандартад заасан зэрэглэл, ажиллах цагт тохирсон хүний нөөцтэй байх. • Нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн, материал хүлээн авах цаг хугацаанд шимтгэлийн өргүй байх.
8.	ААНБ-ын дансны тодорхойлолт; /Харилцагч банкнаас авах/	<ul style="list-style-type: none"> • Хүчинтэй хугацаатай байх
9.	Харьяа татварын тодорхойлолт;	<ul style="list-style-type: none"> • Хүсэлт өгсөн өдрийн байдлаар татварын өргүй байх.
10.	Холбогдох төлбөрийн систем;	<ul style="list-style-type: none"> • Pos 3.0 төлбөрийн баримтын системд холбогдсон байх; (Зургаар баталгаажуулсан байх)
11.	Интернет сүлжээ;	<ul style="list-style-type: none"> • Байнгын, тогтмол ажиллагаатай интернет сүлжээтэй байх; (Интернетийн үйлчилгээ хангагч компанитай байгуулсан гэрээг хавсаргах)
12.	Тухайн бүс нутгийн хэрэгцээ шаардлагад тулгуурлах (Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дата баазаас мэдээлэл авах)	<ul style="list-style-type: none"> • Газар зүйн байршил (google map)-д өөрийн хаяг байршлыг оруулсан байх.

Жич:

- Дээрх шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд эмийн сантай гэрээ байгуулан ажиллана.